



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 163

Улаанбаатар хот

Хүүхдийн эмчилгээнд хүчилтөрөгч  
өтгөрүүлэгч ашиглах технологийг  
сайжруулах тухай

Хүүхдийн өвчлөл, эндэгдлийн тэргүүлэх шалтгаанууд болох амьсгалын цочмог халдвар, нярайн бүтэлт, бусад амь тэнссэн байдлын үед ашигладаг хүчилтөрөгч эмчилгээний технологийн үнэлгээний дүн, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2012 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн хүчилтөрөгч эмчилгээний үр дүнг сайжруулах, өртөг зардлыг бууруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Бүх шатны эмнэлгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгчийн хангалтыг сайжруулах, ялангуяа 24 цаг эрчим хүчээр хангагдсан сумдын эмнэлгийг хүчилтөрөгч өтгөрүүлэгчээр хангах, хүчилтөрөгч өтгөрүүлэгчийн техникийн үйлчилгээ, засварын ажлыг улсын хэмжээнд хариуцан зохицуулах, тушаалын хэрэгжилтэд шаардагдах төсвийг жил бүрийн төсөвт тусгаж, ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Отгонбаатар)-т даалгасугай.
2. Тушаалын хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, Хүүхдийн эмчилгээнд хүчилтөрөгч өтгөрүүлэгч ашиглах нэгдсэн удирдамж боловсруулан батлуулж, мөрдүүлэхийг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Гончигсүрэн)-т үүрэг болгосугай.
3. Хүчилтөрөгч өтгөрүүлэгчийн шүүлтүүрүүд, чийгшүүлэгч, хүүхдэд хүчилтөрөгч өгөх хамрын хос гуурс, маск зэргийг эмнэлгийн хэрэгслийн тендерт тусган, хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, хүчилтөрөгч өтгөрүүлэгчийн ашиглалтын талаар ажлын байран дахь сургалтыг тогтмолжуулахыг эмнэлгийн ерөнхий эмч нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газар (Д.Жаргалсайхан)-т үүрэг болгосугай.

САЙД

Н.ХҮРЭЛБААТАР

080531